

**НИЙГМИЙН
EMPOWERING
ШУДАРГА ЁСНЫ
WOMEN FOR
ТӨЛӨӨ
SOCIAL
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ
JUSTICE
ХҮЧИРХЭГЖҮҮЛНЭ**



2011

ЖИЛИЙН ТАЙЛАН ANNUAL REPORT
ЖИЛИЙН ТАЙЛАН ANNUAL REPORT

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт анд найзууд аа,

Бид эрч хүч, хөдөлмөр зүтгэл шаардсан, амжилт бүтээл дүүрэн нэгэн жилийг ардаа орхилоо.

Монголын Эмэгтэйчүүдийн Сангаас 2001-2010 онд олгосон тэтгэлэгийнхээ үр дүн, үр нөлөө, өөрчлөлтүүдэд үнэлгээ хийлгэлээ. Үнэлгээний санал зөвлөмжийг үндэслэн тэтгэлэг олгох хөтөлбөрийн ойрын таван жилд баримталж ажиллах чиглэлээ тодорхойллоо.

МОНЭС нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд тогтвортой ажиллаж эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, бүлгүүдэд санхүүжилт олгодог үндэсний ганц сан хэвээр байгаа төдийгүй охид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө хөрөнгө босгох, тэтгэлэг олгох шинэ талбарыг нийгэмд бий болгож таниулахын төлөө өөрсдөө суралцан мэргэшин ажилласаар байна гэсэн үнэлгээний дүгнэлт нь биднийг хариуцлагыг улам нэмэгдүүлж эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө хөрөнгө нөөцийг үргэлжлүүлэн хуримтлуулах урам зориг өгч байна.

Бид 2011 онд сонгоно ажиллаж байгаа орон нутгийн эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын чадавхийг бэхжүүлэх, нийгмийн хариуцлагын арга хэрэгслүүдийг ашиглан төсвийн зарцуулалтад хяналт шинжилгээ хийх ур чадварыг нэмэгдүүлэх, бага насны охидыг бэлгийн хүчирхийллээс хамгаалахад бодлого боловсруулагчдад нөлөөлөх чиглэлээр тэтгэлэг авагч байгууллагуудаа дэмжиж ажиллалаа.

МОНЭС нь Азийн эмэгтэйчүүдийн сангуудын сүлжээний гишүүн 5 орны эмэгтэйчүүдийн сантай 2005 оноос хамтран ажиллаж, 2011 оноос бүсийн хэмжээнд «Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь» хамтарсан төслөө хэрэгжүүлж байна. Энэ хамтын ажиллагаа нь бидэнд Азийн бусад орны эгч дүүс сангаас суралцах, шинэ санал санаачлагуудыг өөрийн орны хөрсөнд буулган хэрэгжүүлэх боломжийг олгож байгаад их баяртай байна.

Дотоодоос босгож байгаа хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байгаа нь манай ажлын бас нэг бахархууштай үйл явдал юм.

Биднийг үр бүтээлтэй, тогтвортой ажиллах чухал нэг хөшүүрэг бол ажлын тав тухыг хангасан өөрийн гэсэн ажлын байртай болох явдал байлаа. Энэхүү хүсэлт маань 2011 онд биелэгдэн сургалтын танхим, офиссын өрөө бүхий өөрийн гэсэн ажлын байртай болсон юм.

Бидний үйл хэргийг ямагт дэмжиж, хамтарч байдаг донорууд, хандивлагч нар болон тэтгэлэг авагч нартаа баярлалаа. Нэг баг болж сэтгэл зүрхээ эмэгтэйчүүдийн үйл хэрэгт зориулдаг Удирдах Зөвлөлийнхөн, сайн дурынхан, зөвлөхүүд гүйцэтгэх албаны гишүүддээ сайн сайхныг хүсэн ерөөе

GREETINGS

Dear Friends,

Another year has past, a year full of challenges and successes; energy consuming, but worth of every effort. This year MONES has done an important work: the evaluation of grants, which were disbursed in the period of 2001 – 2010. Now we are able to clearly see the effectiveness and positive changes achieved during implementation of projects. Moreover, this evaluation has helped us in developing our future grant making plan based on the outcomes.

MONES is the only national grant-making organisation that has been supporting women's organisations and groups for the past 10 years and has grown to a nationally recognised and influential women's rights grant-making organisation. MONES is a pioneer in civil society sector by being the first and only national organisation that gives out grants and is raising funds in support of girls' and women's rights. This fact dramatically increases our responsibility and encourages us to proceed with our role as mobilisers of resources for the girls' and women's development.

In the past year we have supported our partners in their work on various issues, including: building capacities of rural women in political participation and increasing their leadership skills; raising awareness on social responsibility and using social responsibility measuring tools to monitor local government budget; and, implementing advocacy campaigns aimed at policy-makers for protection of girls from sexual violence.

MONES is a member of the Asian Network of Women's Funds, which was established in 2005 and last year 5 member funds have embarked on collaborative project for increasing women's political participation in the Asian region. This collaboration has given us the opportunity to learn from sister-funds of the region; adapt and implement newly learned initiatives in Mongolia.

Another highlight of 2011 is we have witnessed gradual increase in the funds raised domestically and we feel delighted seeing philanthropy culture developing.

One of the highlights of 2011, which greatly contributed to sustainability of our operations is an acquirement of own office space. Within the office space we are establishing a training facility which can be used for meetings, trainings and other social gathering for women's organisations and groups.

And lastly, we would like to extend our deepest gratitude to all our supporters, partners and friends, also to our great team of Board members, executive staff and consultants! We wish you all the very best!!











Ш. ЦЭВЭЛМАА
Тэргэцүн
Монгол Улсын Анхны
Тэргэцүн Хатагтай
TSEVELMAA SH.
Head of MONES
Former 1st Lady of
Mongolia











Н.ЧИНЧУЛУУН
Захирал
CHINCHULUUN.N
Director

АГУУЛГА

 Мэндчилгээ	2
 Сан бүрдүүлэлт	4
 Тэтгэлэг олгох хөтөлбөрийн онцлох үйл явдал	7
 2011 онд олгосон тэтгэлэгүүдийн тойм	9
 Гадаад харилцаа ба хамтын ажиллагаа	17
 Санхүүгийн тайлан	20
 Манай хандивлагчид	23
 Манай хамт олон	26

CONTENT

GREETINGS

 Welcome note	2
 Fundraising	4
 Highlights of the grantmaking programme	7
 Grants of 2011	9
 Foreign relations and collaboration	17
 Financial statements	20
 Our donors	23
 Our team	26



Өнгөрсөн жил бид Дэлхийн эмэгтэйчүүдийн сан, Мама Каш сан, Норвегийн Вант Улсын Хөгжлийн Агентлаг, Дэлхийн Банк, Нэн Яаралтай Тусламжийн сан ба Тайваний Ардчиллыг Дэмжих Сангийн дэмжлэгтэй байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангах болон хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн юм. Мөн манай байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд Олон улсын Эмэгтэйчүүдийн сангуудын сүлжээ хувь нэмрээ орууллаа.

Дээрх сангууд болон олон улсын байгууллагуудаас 2011 онд 123.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 23,5 хувийг тэтгэлэгт, 33,3 хувийг нь хөтөлбөрийн үйл ажиллагаа болон хамтын үйл ажиллагааны хөгжлийг хангахад зарцуулсан байна.

Энэ жил бид 2001–2010 онд олгосон нийт тэтгэлэгүүддээ үнэлгээ хийхэд анхаарсан учраас 2011 оны сан бүрдүүлэлт ба тэтгэлэгийн хэмжээ нь харьцангуй бага байлаа.

МОНЭС нь 2011 онд дотоодын эх үүсвэрээр нийт 31,386.6 мянган төгрөгийг хандивын аян, сугалаа, жижиг худалдаа, зэрэг хөрөнгө босгох үйл ажиллагаа ба хандивын дугтуйгаар 269 хүн, 13 байгууллагаас бүрдүүлжээ. Дотоодын хөрөнгө босголт нь 2010 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.

88 ӨДРИЙН КАМПАНИТ АЖИЛ

Хүний эрхийн өдрөөс эмэгтэйчүүдийн эрхийн өдөр хүртэл 88 хоног /2010.12.10-2011.03.08/



«Охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалъя» сэдэвт 88 хоногийн хөрөнгө босгох кампанит аяныг 2004 оноос эхлэн зохион байгуулж байна. Аян нь хүний эрх эмэгтэйчүүдийн эрх болон эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх филантропийн асуудлаар иргэд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудлаар

филантропи хөрөнгө босголтын оргил нь болдог билээ.

Энэ жилийн 88 өдрийн хөрөнгө босгох кампанит ажлыг 88+88 өдөр буюу 12-р сарын 10 –наас 3 сарын 8, 3 сарын 8-наас 6-р сарын 1-ныг өдрийг хүртэлх /Хүний эрхийн өдрөөс Эмэгтэйчүүдийн эрхийн өдөр, Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр/ хугацаанд өрнүүлсэн юм. Аяны хүрээнд хандивын хайрцагийг 13 байгууллагаар аялуулж 631,6 мянган төгрөг, 193 гадаад дотоодын хандивлагч хувь хүмүүсээс хандивын дугтуйгаар 1,392.1 мянган төгрөг нийт 2,023.7 мянган төгрөгийн хандив цуглууллаа. Энэхүү аяны хүрээнд босгосон хөрөнгийг «Бага насны охидыг бэлгийн болзошгүй хүчирхийллээс хамгаалах асуудлаар төр болон төрийн бус байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах болон Төв аймгийн 6 сумын Ерөнхий боловсролын дунд сургуулиудын өсвөр насны охид, хөвгүүдийн «Охид эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах» асуудлаар ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд зориулсан юм.

In 2011, we have received programme and organisational development support from Mama Cash, Global Fund for Women (USA), Norwegian Agency for International Development, Urgent Action Fund, The World Bank and Taiwan Foundation for Democracy. Also, International Network of Women's Funds (INWF) and Women's Funding Network (WFN) have supported us for the capacity building of our fund.

In total, MONES has raised MNT 123.0 million (approx USD 91.5 thousand) from foreign sources, and 23.5 percent of those were used for grants; 33.3 percent for programme implementation and strengthening collaborations and networking.

This year's primer focus was on internal operations, such as grant evaluation, therefore fundraising amount and grants' amount has been comparatively less than in previous years.

From domestic sources we were able to raise MNT 31.4 million (approx USD 23.3 thousand) through fundraising campaigns, small trade, lotto, raffles and other activities from total of 269 individuals and 13 organisations. This year's local fundraising has increased by a fold from previous year.

88 DAYS FUNDRAISING CAMPAIGN

From International Human Rights Day till International Women's Rights Day 88 Days (10th December, 2010 – 8th March, 2011)

Since 2004 MONES has been organising fundraising campaign for protection of girls and women from sexual violence. During the campaign various awareness raising activities are organised aiming at increasing people's understanding and knowledge of human rights, women's human rights and philanthropy for women.

This year the 88 DAYS fundraising campaign was extended for another 88 days and was organised from International Human Rights Day till Children's Rights Day (10th December, 2010 till 1st June, 2011). In the scope of the campaign donation box was placed in 13 business entities raising MNT 631.6 thousand (approx USD 500), and MNT 1.4 million (approx USD 1,100) were collected from 193 individuals, both foreign and local, through donation envelopes, raising total of MNT 2.02 (approx USD 1500).

As the results of this fundraising campaign awareness raising activities aimed at increasing public understanding and knowledge about protection and prevention from sexual violence against little girls were organised. Children of 6 elementary schools of Tuv province have increased their knowledge and understanding of women's and girls' rights and learned about protecting themselves from sexual violence. Furthermore, a discussion forum was organised involving policy-makers and civil society actors on the issue

ФИЛАНТРОПИ СОЁЛЫГ ХӨГЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Бид Олон улсын Филантропчдын өдрийг 9 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ өдрүүдийн үеэр бидэнд байнгын дэмжлэг үзүүлдэг хандивлагчдаа алдаршуулж, тэтгэлэг авагч байгууллага бүлгүүд хэрэгжүүлсэн төслүүдийнхээ үр дүнг хандивлагч нартаа танилцуулдаг билээ.

Энэ удаагийн Олон улсын Филантропчдын өдөр манай сангийн ажлын шинэ байрны нээлттэй давхацсан таатай үйл явдал болж өдөрлөгт хүрэлцэн ирсэн зочид, хандивлагчид болон эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид МОНЭС-д нийт 1,821.4 мянган төгрөг хандивласан ба хандивыг эмэгтэйчүүдийг чадваржуулах сургалтын төв байгуулж, тохилог орчин бүрдүүлэхэд зарцуулла. Сургалтын танхимд зөөврийн компьютер хандивласан БНХАУ-ын ЭСЯ-ны төлөөлөгчдөд МОНЭС-гийн хамт олны нэрийн өмнөөс талархал дэвшүүлье.



«Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг

чадваржуулж, орлогыг нэмэгдүүлье» ХААН Банктай хамтарсан аян

Манай сан 2005 оноос ХААН Банктай хамтран «Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийг чадваржуулж, орлогыг нэмэгдүүлье» уриан дор тус банкны 24 тооцооны төвд байрлах хандивын хайрцагаар хандив цуглуулж байна.

Тус банкны үйлчлүүлэгчид 2011 онд 2,371.0 мянган төгрөгийг хандивлажээ. Энэ хандивыг Улаанбаатар хот, Хэнтий аймаг, Багануур дүүргийн өрх тэргүүлсэн 30 эмэгтэйг чадваржуулахад зарцууллаа.

CULTIVATING PHILANTHROPY CULTURE

MONES has been celebrating International Philanthropy Days for the past 9 years. International Philanthropy days are celebrated from 15th to 30th November each year. All the money that is raised goes for support of capacity and skills building and increase incomes of women with multiple disadvantages (poor, uneducated, unemployed, women with disabilities or those who have children with disabilities, etc).

This year's Philanthropy Celebrations have coincided with official opening of our new office. Guests, consisting of national women's organisations, representatives from multilateral organisations, donors and friends have donated MNT 1.8 million (USD 1.3 thousand) for the establishment and furnishing of our new training venue. Representatives from the embassy of People's Republic of China have donated a notebook. Once again, our sincere thanks to all of supporters of MONES!



Fundraising Campaign in Collaboration with Khan Bank

Since 2005 MONES has raised funds through donation boxes placed in 24 branches of Khan Bank. Funds are raised and spent under the call to «Help Single Mothers with Many Children Increase Their Incomes and Alleviate Women's Poverty».

In 2011 MONES has raised MNT 2.371 million (little over USD 1.7 thousand) through our donation boxes. These monies were used to build capacities of 30 women of Khentii province, capital city and remote Baganuur district.



БАЙГУУЛЛАГА БА ХУВЬ ХҮМҮҮСИЙН ХАНДИВ

DONATIONS FROM ORGANISATIONS AND INDIVIDUAL DONORS

МОНЭС-гийн үйлажиллагааг дэмжиж нийт 16,098.6 мянган төгрөгний хандив өргөсний 14,969,3 мянган төгрөгийг Максам Эксплозивс ХХК нь Багахангай дүүргийн эмэгтэйчүүдийг чадваржуулж, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд зориулан өргөсөн байна.

Maxam Explosives LLC have donated MNT 16.1 million, of which MNT 14.969 million will be used to increase capacities of women's organisations and groups of the remote Bagakhangai district.



МОНЭС-ийн ХҮНДЭТ ХАНДИВЛАГЧ

«Алтан Хурх» ХХК-ний захирал Б.Оюун МОНЭС-гийн байнгын хандивлагч. Сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 300.0 мянган төгрөгийн хандив өргөсөн юм.

MONES' Loyal Supporter – Respected Donor

Ms. Oyun B., Executive Director of Altan Khurkh Co., Ltd is our devoted supporter; she donates on an annual basis and since has donated MNT 300 thousand (approx USD 222).

МОНЭС-ийн хүндэт хандивлагчиддаа талархал илэрхийлье.

We extend our sincere gratitude to all our donors and supporters



ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

МОНЭС-гийн тэтгэлэг олгох хөтөлбөрийн зорилго нь нийгмийн өөрчлөлтийг бий болгохын тулд Монгол дахь эмэгтэйчүүдийн байгууллагууд, бүлгүүд, эмэгтэй тэргүүнтэй ашгийн бус байгууллагуудад сангийн эрхэмлэн тодорхойлсон чиглэлүүдээр удаан хугацааны, тодорхой асуудлыг шийдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд оршино.

ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Тэтгэлэг олгох хөтөлбөрийн үнэлгээ

Монголын Эмэгтэйчүүдийн Сангаас 2001-2010 онд санхүүжилт авсан эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, сүлжээ эвсэл, холбоо бүлгүүдийн хэрэгжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаа хүрсэн үр дүн, үр нөлөө, өөрчлөлтийг үнэлж, түүний үндсэн дээр гарсан шинэ хэрэгцээ сургамж, санал зөвлөмжийг үндэслэн тэтгэлэг олгох хөтөлбөрийн хэтийн хөгжлийн чиглэлийг тодорхойлох явдал 2011 оны онцлох ажил байлаа.

МОНЭС нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд тогтвортой ажиллаж эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, бүлгүүдэд санхүүжилт олгодог үндэсний ганц сан хэвээр байгаа төдийгүй охид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө хөрөнгө босгох, тэтгэлэг олгох шинэ талбарыг нийгэмд бий болгож таниулахын төлөө өөрсдөө суралцан мэргэшин ажиллах болсон байна гэж үнэлгээний дүгнэлтэд тэмдэглэсэн байна.

Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт ба хүчирхийлэл эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх эмэгтэйчүүдийн хөдөлгөөний бэхжүүлэх, давхар хамааралтай эмэгтэйчүүдийг чадваржуулах асуудал нь тэтгэлэгийн үндсэн чиглэл хэвээр байна. Залуу эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч, жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг бууруулах чиглэлээр асуудлыг цогцоор нь шийдэхэд чиглэсэн урт хугацаатай хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүжилтийг олгоход анхаарч ажиллах болно.

GRANTMAKING PROGRAMME

MONES Grantmaking Programme goal is to facilitate social change through establishing long-term partnership with and financially supporting projects implemented by national women's organisations and groups aimed at alleviating status of women and protecting women's rights.

Highlights of the Grantmaking Programme

Evaluation of grants

The purpose of the evaluation was a) to measure the effectiveness, outcomes, achieved successes and impacts of the grants disbursed to women's organisations, groups, and networks by Mongolian Women's Fund (MONES) in the period of 2001 – 2010; and b) to develop a 5 year strategic grant-making plan based on the «lessons learnt», recommendations and outcomes of the evaluation.

One of the outcomes of the evaluation has been recognition of MONES being a pioneer in civil society sector by being the only national organisation that gives out grants and is raising funds in support of girls' and women's rights. MONES has been working sustainably for the past 10 years and during that period has supported women's groups and organisations not only financially, but also providing technical assistance.

According to evaluation recommendations MONES should pursue its current grantmaking strategic plan of supporting organisations working on: 1. Elimination of gender based violence and discrimination; 2. Increasing women's political participation; 3. Building capacities of women with multiple disadvantages; and 4. Fostering women's movement. It was specially noted to support programmes aimed at fostering movement of young women and increasing their activism and participation, as well as establishing long-term collaborations and partnerships with rural women's organisations on eliminating gender based structural inequalities.



МОНЭС-гаас тэтгэлэг авсан эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, бүлгүүд болон хандивлагчдын уулзалтыг 2011 оны 06-р сарын 13-14-ний өдөр зохион байгуулаа. Уулзалтад «**Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эхчүүдийг чадваржуулах нь**» чиглэлээр 2010 онд төсөл хэрэгжүүлсэн Улаанбаатар

хотын СХД-ийн Уран хатгамалч бүлэг, Захын гэр хорооллыг хөгжүүлэх эмэгтэйчүүдийн «Эхлэл» холбоо болон «Эмэгтэйчүүд-Амьдрал төв» төрийн бус байгууллага, Ховд аймгийн Жаргалант сумын эмэгтэйчүүдийн бүлгүүд хандивлагч нартаа төслийн үр дүнгээ танилцууллаа. Төслийн үр шимийг 42 эмэгтэй хүртсэн бөгөөд энэ хугацаанд тэд хийж байгаа бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зэргээр өөрөө өөртөө ажлын байр бий болгож, өрхийн орлогоо нэмэгдүүлж, бүлгийн дундын сан үүсгэж эргэлтийн хөрөнгөтэй болсон байна. Тухайлбал Уран хатгамалч эмэгтэйчүүдийн бүлэг энэ хугацаанд 157.0 мянган төгрөг дундын сандаа хуримтлуулжээ. Ховд аймгийн Жаргалант сумын 5 эмэгтэй хамтран оёдлын бүлэг байгуулан ажиллаж, одоо оёдол хийх ажлын байртай болохоор хамтран ажиллаж байна.

Уулзалтад 20 гаруй хандивлагч оролцон, тэдний хандив хэрхэн зарцуулагдаж байгаа талаар мэдээлэл авлаа. .



Хандивлагч Ж.Лхам: Би МОНЭС-ийн ууган хандивлагчдын нэг. Жил бүр 100,0 мянган төгрөгний хандив өргөдөг. Хүний тус багаддаггүй гэдгийг би эмэгтэйчүүдийн ярианаас олж мэдсэндээ их баярлаж байна.

Хандивлагч Б.Эрдэнэцогт: 2005 оноос эхлэн МОНЭС-гийн Сайн дурын ажилтнаар ажиллаж байна. Би орон нутагт сургалтаар явахдаа МОНЭС-гийн үйл ажиллагааг танилцуулж, хандив цуглуулдаг, 2010 онд 238,0 мянган төгрөгний хандив цуглуулсан. Миний Замын-Үүдэд ажиллахдаа цуглуулсан хандив Уран хатгамалч эмэгтэйчүүдийн бүлгийн төслийн санхүүжилтийн нэг хэсэг болон зарцуулагдаж, энэ нь эмэгтэйчүүдийг чадваржуулахад хувь нэмэр оруулсныг хараад их баярлаж байна.

This meeting was organised in 13-14 June, 2011. Donors have met grantee-partners, whose projects they have supported in 2010. These projects were implemented in the scope of our call on «**Alleviating Poverty among Women: Supporting Single Mothers with Many Children Through Building Their Capacities**» and were implemented by «Arty Embroiderers» group of Songino-Khairkhan district of the capital city; «Initiation» group of women for the development of sub-urban areas of the capital city; «Women - Life Centre» NGO and women's groups from Jargalant soum of Khovd province. In total 42 women have benefited from these projects, increasing their capacities in design and quality of handcrafts and improved creating new products, thus increasing their income from the sales of their handcrafts. Some groups now have mutual savings accounts, for example, «Arty Embroiderers» group have an endowment fund of MNT 157 thousand (USD 120); 5 women from Jargalant soum of Khovd province have established their sewing business and now are on the way to acquire their own venue.



Over 20 individual donors have attended meeting and were happy to see the results of their donations.

Lkham J., Individual Donor: «I am one of the oldest donors of MONES. Each year I contribute MNT 100 thousand. And I am more than satisfied with the results of my contributions and from women I have learned that help is never too little.»

Erdenetsogt B., Individual Donor: «Since 2005 I am MONES volunteer. Each time I travel to rural areas I present MONES' work and raise funds. In 2010 I have raised MNT 238 thousand (USD 160). I am very happy to learn that funds I have raised during my past work in Zамын-Ууд have been a contribution to Arty Embroiderers project and served to increase women's capacities.»

1. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ХҮЧИРХИЙЛЛИЙГ БАГАСГАХ

«Бага насны охидыг хүчингийн гэмт хэргээс хамгаалах аюулгүй орчин бүрдүүлэх нь» олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил



Энэхүү кампанит ажлыг «Бага насны охидыг хүчингийн гэмт хэргээс хамгаалах аюулгүй орчин бүрдүүлэх нь» сэдвийн дор Иргэдэд туслах Хүний эрхийн төв зохион байгуулсан ба бага насны хүүхдийг



хүчингийн гэмт хэргээс хамгаалах талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх сурталчилгаа хийлээ. Кампанит ажилд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах Гүнж төв, Хүний эрх хөгжил төв зэрэг ТББ-ууд оролцон өөрсдийн үйл ажиллагаа олон нийтэд танилцуулсан. Мөн кампанит ажлын үеэр хүүхдийг болзошгүй бэлгийн хүчирхийллээс сэргийлэх ажлыг дэмжигчдийн гарын үсгийг цуглууллаа.

Хүүхдийн бэлгийн халдашгүй байдал ба бэлгийн болзошгүй хүчирхийллээс хамгаалах нь» сэдэвт Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимын нээлттэй хэлэлцүүлэг



Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимтай хамтран зохион байгуулсан «Хүүхдийн бэлгийн халдашгүй байдал ба бэлгийн болзошгүй хүчирхийллээс хамгаалах нь» хэлэлцүүлэгт төр, төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцож, энэ асуудлын өнөөгийн нөхцөл байдал ууль эрх зүйн орчны дүн шинжилгээ болон үзүүлж

байгаа үйлчилгээний чанар хүртээмжийн асуудлаар саналаа солилцох цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарлаа хандууллаа.

Хэлэлцүүлэгт оролцогсад Эрүүгийн хууль, Эрүүгийн Байцаан шийтгэх хууль, Гэрч хохирогчийг хамгаалах хуульд өөрчлөлтүүд оруулах ажлын хэсэг байгуулсан юм. Мөн бүх төрлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх «Нэг цэгийн үйлчилгээ»-ний зохицуулалт, механизмыг сайжруулах хэрэгтэй байгаа талаар саналаа илэрхийллээ.

1. GENDER BASED VIOLENCE AND DISCRIMINATION

«Every Child Has the Right to Live in a Violence Free Environment» Awareness Raising Street Campaign



This campaign aimed at increasing public awareness of the issue of school molestation against little girls and violence they face in their homes. Our partner Civil Protection Human Rights Centre has been the main organiser for this campaign and other NGOs have participated, these are: National Centre against Violence, Princess Centre - young women and girls' rights NGO, Human Rights and Development NGO.



«Children's Right to Safe Environment and Protection from Sexual Violence» Open discussion Civil Society Cabinet by the President's Office

On 30th May open discussion was organised with support of the Consultant for Presidnet's Human Rights Department Ms. Sosormaa. This discussion was attended by representatives from government and civil society. Discussion topics covered legal environment and current situation with legal protection; safety issues of schools and kindergartens; quality of services provided to victims and improvement of services of One-Stop Service Centres.

After presentations participants have shared their opinions and working groups were set to work on amendments to the Family Code and also Criminal Code. Amendments included re-defining «rape» with inclusion of all types of it, and not limit it to only physical. Simplifying filing and processing of complaint, and also legalize free legal and medical services. Discussions over creating special interview rooms for children at Police Stations raised high interest and attention.

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн»Нэг цэгийн үйлчилгээ» тандалтын судалгаа

МОНЭС-гийн санхүүжилтээр Иргэдэд туслах Хүний эрхийн төвөөс «Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн «Нэг цэгийн үйлчилгээ»-ний төвөөр үйлчлүүлсэн бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмжийг судлах зорилгоор тандалтын судалгаа хийсэн.

«Нэг цэгийн үйлчилгээний төв нь» хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчид үзүүлэх шинээр бий болсон үйлчилгээ бөгөөд Гэмтэл согог судлалын үндэсний төв, ХЗДХЯ-ны харьяа Шүүх эмнэлэг, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл дээр байгуулагдан «Нэг цэгийн үйлчилгээ»-ний төв 2010 оноос эхлэн ажиллаж байна.

Нэг цэгийн үйлчилгээний 3 төвөөр 2010 он болон 2011 оны эхний хагас жилийн байдлаар нийт 774 хүн үйлчлүүлснээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн 71 хүүхэд байна. Шинээр бий болсон үйлчилгээний эцсийн дүнг тооцоход эрт байгаа хэдий ч энэ үйлчилгээ бий болсноор хүчирхийлэл даамжирч, давтагдаж хүнд хэлбэрт шилжихээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хойно нь тусламж үйлчилгээ үзүүлэхээс илүүтэй эрт шатанд нь илрүүлж таслан зогсоох, хүчирхийллийг даван туулах мэдлэг мэдээллээр хангах санал зөвлөмжүүдийг өгөх, хохирогчдыг хэрэгцээт мэдээллээр хангаж, дараачийн шатанд авах арга хэмжээг зангидан, байнгын эргэх холбоотой ажиллаж салбар хоорондын уялдаа сайжирч байна гэс дүгнэлт хийлээ

2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

A. Төсөвт оролцох эмэгтэйчүүдийн оролцоо

Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг, Баянгол дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын зарцуулалтын хяналт шинжилгээ



Нийгмийн хариуцлагын арга хэрэгслүүдийн нэг болох төсвийн зарцуулалтын хяналт шинжилгээг ашиглан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ГХУС зардалд дүн шинжилгээ хийж төсвийг олон нийтэд ил тод болгон сайн засаглалыг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг зорьсон юм.

Төслийг хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал ИТХ-д сонгогдон ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгч, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага болон орон нутгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнуудаас бүрдсэн 4 баг ажиллаж, ГХУСА-ын 2009, 2010 оны зарцуулалтад дүн шинжилгээ хийсэн юм. Төсвийн зарцуулалтад дүн шинжилгээ хийсний үр дүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийг төлөвлөх, зарцуулах, хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд хамгийн хүртээмжтэй мэдээллийн эх сургуулаар дамжуулан төсвийн зарцуулалтыг олон нийтэд ил тод болгох хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон юм.

Services Provided by One-Stop Service Centres to Victims of Sexual and Domestic Violence Observation study

Civil Help Human Rights Centre has conducted an observation of the services provided by One-Stop Service Centres, established in three locations in Ulaanbaatar city. Observation prioritised the following criteria: services accessibility, affordability and overall quality.

One-stop Service Centres have been established in the end of 2009 and are relatively new concepts. Total of three Centres are established in Ulaanbaatar city in the premises of National Research Centre of Injuries and Defects; Court Clinic by the Ministry of Justice and Home Affairs and in Health Centre of Sukhbaatar district.

In the first half of 2011 total of 774 people received One-Stop Service Centres' services; of these people 71 were children. These Services Centres were established in late 2009 and are still in piloting process, therefore, it is early to give full evaluation to operations and services of the Centres, nevertheless some of the positive outcomes were reported. For instance, it was pointed out that the focus of the Centre was not only on providing quality post-violence services, but they have been working on improving preventive services, such as developing awareness raising and training programmes for victims and general public on overcoming, preventing and avoiding sexual violence; and on improvement of information infrastructure connecting all related agencies and institutions.

2. WOMEN'S PARTICIPATION IN DECISION- AND POLICY- MAKING LEVELS

A. Women monitoring local budgets

Monitoring of Allocated Budget of the Commission on Prevention of Crime of Dornod, Khentii, Sukhbaatar provinces and Baganuur district



The goal of the project was to increase women's participation and achieve transparent government through monitoring Commission's budget by using social responsibility tools and opening the information to public. This project was implemented by established working groups consisting of women from Civil Khural (local council) of each province and district, local civil society activists and officers of local governments. Budgets of 2009 and 2010 were monitored and the need of enforcing government transparency for better involvement of public in planning and spenditure monitoring of the Commission was stressed. Participating public also identified the need to have that information shared constantly through most accessible information and media outlets.

Outcomes of the monitoring were presented to employees of local Commissions on Prevention of Crime and Civil Khural members, where decision of allocating a part of the money for preventive measures of domestic violence was made. Women's NGOs have received additional funding for advertising and promoting information for raising awareness and facilitating public participation.

Хяналт шинжилгээний дүгнэлтийг аймгуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хуралд танилцуулж, 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд гэр бүлийн хүрээнд гарч байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд тодорхой хэмжээний зардал төсөвлөж, сурталчилгаа хийх ажлыг эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд хариуцан гүйцэтгэхээр боллоо.

Б. Улс төрд оролцох эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Говь-Алтай, Дорноговь аймгийн эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал нөлөөллийн чадавхийг бэхжүүлэх



Хонг Конг, Энэтхэг Монгол, Бангладеш Непал зэрэг Азийн 5 улсын Эмэгтэйчүүдийн сангууд эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог нэмэгдүүлэх хамтарсан төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Төслийн хүрээнд «Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хаана байна вэ?» судалгаа хийж

МОНЭС үр дүнгээ хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан шийдвэр гаргагчдад нөлөөлөх ажлыг хийлээ.

Орон нутгийн эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог нэмэгдүүлэх уулзалтууд болон эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, нөлөөллийн чадавхийг бэхжүүлэх сургалтыг Говь-Алтай, Дорноговь, Дорнод аймагт зохион байгууллаа. МОНФЕМНЕТ үндэсний сүлжээний боловсруулсан арга зүйд суралцсан сургагч багш нар эмэгтэйчүүдийн хүний эрхэд суурилсан арга зүй, хандлага, улс төр, эрх мэдэл, жендерт суурилсан ялгаварлан гадуурхалт шинэ манлайлал, нөлөөллийн шинэ стратеги, тактикийн асуудлаар эмэгтэй манлайлагчдын чадавхийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлээ. Сургалтын нэг онцлог бол 30-аас дээш настай болон 30-аас доош настай тус бүр 20 эмэгтэй сургалтад оролцсон юм.

Сургалтад оролцсон эмэгтэйчүүд 2012 онд болох орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг идэвхжүүлэх эмэгтэйчүүдийн хандлагыг өөрчлөх, сонгогчдын хандлагыг өөрчлөх гэсэн чиглэл гарган ажиллаж эхэлсэн ба хамтран ажиллахаар зөвшилцлөө.



Outcomes of the monitoring were presented to employees of local Commissions on Prevention of Crime and Civil Khural members, where decision of allocating a part of the money for preventive measures of domestic violence was made. Women's NGOs have received additional funding from the World Bank for advertising and promoting information for raising awareness and facilitating public participation.

B. Women's political participation

Building leadership and advocacy capacities of women's organisations in Gobi-Altai and Dornod provinces

Women's funds of Hong Kong, India, Nepal, Bangladesh and Mongolia have conducted a collaborative research project «Where is the Money for Women's Political Participation in Asia». This project's main goal was to find and analyse available sources of funding for supporting programmes aimed at increasing women's political participation. Although, the whole regional research is not finalised yet, MONES has published outcomes and conducted media advocacy campaign in the end of 2011.

Movement building meetings and trainings on increasing rural women's leadership and advocacy skills were conducted in Gobi-Altai, Dornogobi and Dornod provinces. Rural women-leaders, as well as women-candidates running for the 2012 elections, have attended trainings on gender equality, politics and human rights approach, new ways of leadership and advocacy strategies and tactics. This comprehensive training programme for trainers was developed by our partner – MONFEMNET – National Network of Women's NGOs.



One of the special sides of this programme was that women were divided to two groups according to their age: over and under 30, and each group had 20 participants. Participants were selected according to their own wish and their activism in political and social arenas of their communities. Women-participants have developed a collaborative action plan for improving voters' education, especially mobilising women voters, and increasing social

awareness of women already working in government and women-representatives of political parties.



3. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ БЭХЖҮҮЛЭХ

«Эмэгтэйчүүдийн нүдээр-Нээлттэй засаглал» Чуулган



Монголын эмэгтэйчүүдийн сангаас анх санаачлан, санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан «Эмэгтэйчүүдийн нүдээр» чуулган цар хүрээгээ тэлж, жил бүр нийгэмд тулгамдаж байгаа асуудлуудын талаар эмэгтэйчүүдийн дуу хоолойг олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэх чухал индэр болж байна. Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын үндэсний сүлжээ-МОНФЕМНЕТ-ээс зохион байгуулсан энэ жилийн чуулган «Эмэгтэйчүүдийн нүдээр-Нээлттэй засаглал» сэдвийн хүрээнд болж, нийт 300 орчим эмэгтэйчүүд оролцлоо.

Чуулганаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дүгнэлт хийж, санал зөвлөмж боловсруулсан байна. Чуулган нь сонгуулийн хуулийг шинэчлэх үйл явц, 2012 онд болох ээлжит сонгуультай холбогдуулан УИХ, улс төрийн намуудад хандсан шаардах бичгийг гарган, чуулганы эмхтгэлийн хамт УИХ-ын гишүүд, улс төрийн намууд болон төрийн захиргааны байгууллага орон нутгийн байгууллага болон гишүүд, түншлэгчиддээ хүргэсэн. Чуулган зохион байгуулахад Монголын эмэгтэйчүүдийн сангаас гадна Номадсын сүлжээ ресторан, Швейцарийн хөгжлийн агентлаг санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Залуу эмэгтэйчүүдийн дуу хоолой 2-р форум



Хүний эрх, тэр дундаа эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн тэгш эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын дэргэдэх охидын клуб, бүлгүүд ялгаварлан гадуурхдаггүй, хүн бүрийн эрхийг хангасан, нээлттэй, ил тод засаглалтай, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийн төлөө өөрсдийн хувь нэмрээ оруулах зорилгоор «Залуу эмэгтэйчүүдийн дуу хоолой» хоёрдугаар форумыг МОНФЕМНЕТ, Охид, залуу

эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах «Гүнж» төв, МОНЭС-гийн дэргэдэх Залуу лидер эмэгтэйчүүдийн клубын гишүүд, «Эрхийнхээ төлөө гараа өргөцгөө» аяны залуучууд хамтран зохион байгуулсан юм. Форум нь «Эрхээ мэдье эрхээ эдэлье!» сэдвийн дор зохион байгуулллаа. Форумд оролцогсод «Сурч боловсрох эрх», «Нөхөн үржихүйн эрүүд мэндийн эрх», «Хөдөлмөрлөх эрх» «Шинэ манлайлал», «Иргэний оролцоо» –ны талаарх мэдлэгээ нэмэгдүүлж «би бол манлайлагч, миний оролцоо нийгмийн өөрчлөлтийг авчирч чадна» гэдэгтээ итгэх итгэлийг залуу эмэгтэйчүүдэд бий болгоход чухал ач холбогдолтой боллоо.

3. FOSTERING WOMEN'S MOVEMENT

«Through Women's Eyes: Open Governance» National Annual Forum

In 2005 MONES has initiated and was the only funder in the early years of the national annual forum. «Through Women's Eyes» Since then the forum has gained recognition as the only platform for civil society activists, where the government policies and laws are discussed with the relation to women's rights and needs. Forum was organised by MONFEMNET with a theme of «Through Women's Eyes – Open Governance», where over 300 activists from all over country have attended. During the forum government's current action plan was discussed and women activists have developed a list of recommendations for the government to work in collaboration with the civil society in order to create a government, which is open, responsible and respectful of human rights.



Another set of recommendations was developed, prior to elections of 2012, to advocate and call for national and local parliaments, political parties and government agencies, civil society organisations and activists to increase capacities of parliament members and politicians for better representation of citizens' interests, and have these recommendations incorporated in the process of amendment of the Election Law.

Forum was supported by MONES, «Modern Nomads» chain restaurant and Swiss Cooperation for Development.

«Young Women's Voice» 2nd Forum

Young women's clubs and groups, established by women's rights NGOs, such as MONFEMNET, Princess Centre's Girls Club, «Hands Up for Your Rights» youth movement and MONES' Young Women-Leaders Club have organised their own «Young Women's Voice» forum to contribute to the development of just and non-discriminatory; open and transparent; accountable and humane government, which is respectful of human rights and committed to creating democratic and humane society. This forum was organised under the call: Know and Enjoy Your Rights! forum participants have discussed and increased their knowledge on basic human rights, such as right for education, sexual and reproductive rights and right to work. Also, they have discussed young people's participation in political agenda of the country and trends of leadership and these young people have built their own self-confidence under a notion: I am a leader; my participation will bring social change!

Багахангай дүүргийн эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх

